

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/51/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.govisumber@audit.gov.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: batsaikhants@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3.Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	12
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2. Төлбөрийн акт байхгүй	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15

Товчилсонүгийнжагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН

ЗУРГААДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.БОЛОРМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,696,811.00	86,827,906.20
33	АВЛАГА	1,518,602.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,518,602.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,178,209.00	86,827,906.20
35100	Түүхий эд материал	674,700.00	423,000.00
35130	Эм боох материал	674,700.00	423,000.00
35400	Хангамжийн материал	74,503,509.00	86,404,906.20
35410	Бичиг хэргийн материал	104,700.00	332,800.00
35420	Аж ахуйн материал	4,299,900.00	2,743,900.00
35460	Хүнсний материал	323,900.40	4,667,670.40
35470	Бусад хангамжийн материал	69,775,008.60	78,660,535.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	787,164,264.17	737,433,226.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	787,164,264.17	737,433,226.37
39200	Биет хөрөнгө	764,500,764.09	715,013,726.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	787,600,000.00	787,600,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-66,210,000.00	-107,220,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	35,511,020.00	35,511,020.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-6,973,412.34	-12,218,555.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,022,272.00	19,022,272.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,449,115.57	-7,681,009.81
39300	Биет бус хөрөнгө	22,663,500.08	22,419,500.12
39301	Програм хангамж	1,220,000.00	1,220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-480,499.92	-724,499.88
39303	Бусад биет бус хөрөнгө	21,924,000.00	21,924,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	863,861,075.17	824,261,132.57
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	863,861,075.17	824,261,132.57
51	Засгийн газрын хувь оролцоо	863,861,075.17	824,261,132.57
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,924,000.00	21,924,000.01
51200	Хуримтлагдсан үр дүн	841,937,075.17	802,337,132.57
51210	Өмнөх үеийн үр дүн	864,654,490.08	841,937,075.17
51220	Тайлант үеийн үр дүн	-22,717,414.91	-39,599,942.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	863,861,075.17	824,261,132.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	430,484,465.00	341,907,934.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,891,065.00	9,555,934.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,891,065.00	9,555,934.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	10,752,284.00	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,138,781.00	9,555,934.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	406,593,400.00	332,352,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	372,854,400.00	300,997,000.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	372,854,400.00	300,997,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	111,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	111,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,739,000.00	31,244,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,739,000.00	31,244,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	453,201,879.91	381,507,876.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,201,879.91	381,507,876.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,816,931.91	378,607,412.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,440,168.00	244,208,412.00
210101	Үндсэн цалин	217,440,168.00	244,208,412.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,679,889.00	31,886,765.00
210201	Тэтгэврийн даатгал	19,206,495.00	22,399,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,174,403.00	2,449,484.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,739,520.00	1,952,867.00
210204	Ажилгүйдлийн даатгал	414,496.00	462,246.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,144,975.00	4,622,468.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,929,247.00	24,332,211.00
210301	Гэрэл, цахилгаан	3,418,349.00	2,901,776.00
210302	Түлш, халаалт	19,028,200.00	18,712,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,482,698.00	2,718,435.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,468,787.00	10,777,465.80
210401	Бичиг хэрэг	611,500.00	909,800.00
210402	Тээвэр, шатахуун	298,700.00	362,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	305,800.00	70,200.00
210404	Ном, хэвлэл	32,500.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,144,049.00	4,235,550.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	1,501,600.00
210408	Бараа материал акталсны зардал	1,076,238.00	3,698,215.80
2105	Нормативт зардал	22,973,385.00	16,046,421.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,573,300.00	604,591.00
210502	Хоол, хүнс	21,400,085.00	15,441,830.00
2107	Томилолт, зочны зардал	71,200.00	77,100.00
210702	Дотоод албан томилолт	71,200.00	77,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,300,000.00	882,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	662,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,954,255.91	50,397,037.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	367,500.00	660,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	6,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,586,755.91	49,731,037.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,384,948.00	2,900,464.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	2,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	2,040,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,870,753.00	598,189.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,870,753.00	598,189.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,514,195.00	262,275.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,514,195.00	262,275.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-22,717,414.91	-39,599,942.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-22,717,414.91	-39,599,942.60

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	864,654,490.08	864,654,490.08
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	864,654,490.08	864,654,490.08
3	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	21,924,000.00	0.00	0.00	21,924,000.00
4	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-22,717,414.91	-22,717,414.91
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,924,000.00	0.00	841,937,075.17	863,861,075.17
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	21,924,000.00	0.00	841,937,075.17	863,861,075.17
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,924,000.00	0.00	841,937,075.17	863,861,075.17
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-39,599,942.60	-39,599,942.60
10	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	21,924,000.00	0.00	802,337,132.57	824,261,132.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	406,593,400.00	332,352,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	406,593,400.00	332,352,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	372,854,400.00	300,997,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	372,854,400.00	300,997,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	111,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	111,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,739,000.00	31,244,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,739,000.00	31,244,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	405,993,400.00	332,352,000.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	405,993,400.00	332,352,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,608,452.00	329,451,536.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,426,441.00	240,422,975.00
210101	Үндсэн цалин	174,013,096.00	160,973,262.00
210102	Нэмэгдэл	22,132,615.00	61,865,693.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,906,600.00	7,256,000.00
210104	Урамшуулал	16,374,130.00	10,328,020.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,492,850.00	34,153,600.00
210201	Тэтгэврийн даатгал	18,328,566.00	23,219,448.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,832,856.00	2,276,902.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	458,217.00	569,231.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,582,141.00	5,241,884.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,291,070.00	2,846,135.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,929,247.00	24,332,211.00
210301	Гэрэл, цахилгаан	3,418,349.00	2,901,776.00
210302	Түлш, халаалт	19,028,200.00	18,712,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,482,698.00	2,718,435.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,648,000.00	732,650.00
210401	Бичиг хэрэг	0.00	95,500.00
210402	Тээвэр, шатахуун	298,700.00	362,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	305,800.00	70,200.00
210404	Ном, хэвлэл	92,500.00	69,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,951,000.00	135,450.00
2105	Нормативт зардал	17,267,615.00	20,528,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	170,000.00	174,800.00
210502	Хоол, хүнс	16,644,215.00	19,785,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	453,400.00	568,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,339,000.00	6,313,600.00
210604	Урсгал засвар	2,339,000.00	6,313,600.00
2107	Томилолт, зочны зардал	71,200.00	77,100.00
210702	Дотоод албан томилолт	71,200.00	77,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,300,000.00	882,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	662,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,134,099.00	2,009,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	367,500.00	660,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,766,599.00	1,349,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,384,948.00	2,900,464.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	2,040,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	2,040,000.00

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,870,753.00	598,189.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,870,753.00	598,189.00
213404	Хөрөнгийн	0.00	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,514,195.00	262,275.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,514,195.00	262,275.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	600,000.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	600,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	600,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	600,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	600,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-600,000.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,241,000.00	331,380,536.00	860,464.00	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,241,000.00	331,380,536.00	860,464.00	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,201,000.00	329,340,536.00	860,464.00	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,623,900.00	240,422,975.00	200,925.00	99.
210101	Үндсэн цалин	174,551,600.00	160,973,262.00	13,578,338.00	92.2
210102	Нэмэгдэл	48,748,200.00	61,865,693.00	-13,117,493.00	126.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,085,000.00	7,256,000.00	-5,171,000.00	348.0
210104	Урамшуулал	15,239,100.00	10,328,020.00	4,911,080.00	67.
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,153,600.00	34,153,600.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	25,874,100.00	23,219,448.00	2,654,652.00	89.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,056,700.00	2,276,902.00	-220,202.00	110.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,659,400.00	569,231.00	1,090,169.00	34.3
210204	Ажилгүйдлийн даатгал	414,900.00	5,241,884.00	-4,826,984.00	1,26.
210205	Эрүүл мэндийн даатгал	4,148,500.00	2,846,135.00	1,302,365.00	68.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,928,000.00	24,332,211.00	595,789.00	97.6
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,901,776.00	98,224.00	96.7
210302	Түлш, халаалт	18,928,000.00	18,712,000.00	216,000.00	98.8
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	2,718,435.00	281,565.00	90.6
2104	Хангамж, бараа материалын зардал	733,100.00	732,650.00	450.00	99.9
210401	Бичиг хэрэг	95,500.00	95,500.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	362,100.00	362,100.00	0.00	100.0

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,300.00	70,200.00	100.00	99.8
210404	Ном, хэвлэл	69,400.00	69,400.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	135,800.00	135,450.00	350.00	99.7
2105	Нормативт зардал	20,474,900.00	20,417,400.00	57,500.00	99.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,800.00	63,800.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	19,798,400.00	19,785,600.00	12,800.00	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	612,700.00	568,000.00	44,700.00	92.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,316,000.00	6,313,600.00	2,400.00	99.6
210604	Урсгал засвар	6,316,000.00	6,313,600.00	2,400.00	99.9
2107	Томилолт, зочны зардал	77,100.00	77,100.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	77,100.00	77,100.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	882,200.00	882,000.00	200.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	662,200.00	662,000.00	200.00	99.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	220,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,012,200.00	2,009,000.00	3,200.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	662,200.00	660,000.00	2,200.00	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,350,000.00	1,349,000.00	1,000.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,040,000.00	2,040,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,040,000.00	2,040,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,040,000.00	2,040,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	332,241,000.00	331,380,536.00	860,464.00	99.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	300,997,000.00	300,734,725.00	262,275.00	99.9
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	300,997,000.00	300,734,725.00	262,275.00	99.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,244,000.00	30,645,811.00	598,189.00	98.0
320001	Орон нутгийн төсвөөс	31,244,000.00	30,645,811.00	598,189.00	98.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	129.00	129.00	0.00	129.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	1.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	1.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00	0.00	14.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	0.00	9.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	4.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	111,000.00
2105	Нормативт зардал	111,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	111,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Г.Хүрэл гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны хяналтыг Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэг үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Сайн үйлийн эзэн болох хүүхэд бүрийн хувийн онцлог шинжийг нээх,дэмжих,боломжит хурдаар нь хөгжүүлэхэд голлон анхаарч тэдний эцэг эхэд бүрэн дүүрэн сэтгэл ханамжийг өгч ажиллахыг эрхэмлэнэ”

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгууллагын менежментийг бий болгох;

- Хүүхдийн хөгжлийг дэмжсэн эрүү, аюулгүй орчин бүрдүүлэх;
- Багш ажилтнуудыг чадваржуулах, хариуцлагажуулах;
- Хүүхдийн дотоод сэтгэл, авъяас сонирхолд тулгуурласан чанартай сургалтыг зохион байгуулах;
- Хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” хүчингүй болж, 2021 оны 190 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан.
- Боловсрол, шинжлэх Ухааны Сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сайд, Сангийн Сайдын хамтарсан тушаал 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дугаар А/35/А/10/9.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны баталсан төсвийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлыг 2021 оны баталсан төсвийн нийт зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 332,241.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 6,644.8 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувиар 4,983.6 мянган төгрөгөөр тогтоов.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,599.9 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,518.6	-	(1,518.6)
Бараа материал	75,178.2	86,827.9	11,649.7
Бусад эргэлтийн хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	787,164.2	737,433.2	(49,731.0)
Нийт хөрөнгө	863,861.0	824,261.1	(39,599.9)
Богино хугацаат өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	863,861.0	824,261.1	(39,599.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	863,561.0	824,261.1	(39,599.9)

Авлагын дансны эхний үлдэгдэл 1,518.6 мянган төгрөгийг барагдуулсан ба тайлант онд шийнээр авлага үүсгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86,827.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,649.7 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар бусад хангамжийн материал хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 49,731.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 824,261.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 39,599.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хасах үр дүнтэй ажилласантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 88,576.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дараах орлогууд байна. Үүнд: үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 14,335.1 мянга, улсын төсвийн санхүүжилт 71,857.4 мянга, орон нутгийн төсвийн санхүүжилт 2,495.0 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 71,694.0 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа ажил үйлчилгээний зардал 28,790.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, урсгал шилжүүлэг 100,484.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 398,500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 11,341.8 мянган төгрөгөөр бууруулж, 387,158.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 86,161.2 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 31,244.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 332,241.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 300,997.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 31,244.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилт 332,158.1 мянган төгрөгийн авч, урсгал үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.4 хувьтай байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” шийдвэрийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 111.0 мянган төгрөгийг олгосныг норматив зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл нь 82.0 хувийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, стандарт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй тул санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зорицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулахаас 141 мэдээллийг байршуулж, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулах 1, сар бүрийн оруулах 3, улирал бүр оруулах 1, бүтэн жилээр оруулах 2 төрлийн мэдээлэл, нийт 8 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Татварын ерөнхий хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд нийт 23.432.1 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс цахим худалдан авалтын баримтын системд 13.648.0 мянган төгрөгийн баримтыг шивүүлж, баталгаажуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн цахим төлбөрийн баримтын мэдээлэл нь Татварын ерөнхий хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт 5, зөвлөмж 3, албан шаардлага 3 өгсний, шилэн дансны мэдээлэлийг хугацаа хоцроосон, татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй гэсэн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, тайлант онд зөрчил давтагдсан байна.

Хүснэгт-2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,240.1	1	3,240.1			100
Зөвлөмж	5	109,775.3	5	109,775.3			100
Албан шаардлага	3	81,080.7	3	81,080.7		-	100
Нийт дүн	9	194,096.1	9	194,096.1		-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22,280.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6,781.6 мянган төгрөгийн бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдааг залруулан, 13,648.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,850.8 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 6,781.6 мянган төгрөгийн санхүүгийн тайлагнал, бүртгэлтэй холбоотой дараах алдааг залруулж, баталгаажууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь хангамж бараа материалын зардалд 468.0 мянган төгрөгийг нормативт зардлаас шилжүүлж тайлагнасан,
- Эд хогшил, урсгал засварын зардлын 6,313.6 мянган төгрөгийн зардлыг тайлагнаагүй зөрчлүүдийг аудитын явцад залруулав.

4.2. Төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

4.3.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 23,432.1 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс цахим худалдан авалтын баримтын системд 13,648.0 мянган төгрөгийн баримтыг шивүүлж, баталгаажуулаагүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

4.3.2 Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

1. Бүтэц, орон тоотой холбоотой

1.1 Илрүүлэлт:

Байгууллагын бага эмчийг эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр орон тооноос илүү ажиллуулан, 1,680.0 мянган төгрөгийн цалин олгож, үргүй зардал гаргасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д: "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Баталсан орон тооны хязгаарт багтааж ажиллах

2. Санхүүгийн тайлагналтай холбоотой

2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлын дүнгээс нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн дүнг 170.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д заасан "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Зардлыг зөв ангилж бүртгэн, тайлагнаж байх.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

3.1 Илрүүлэлт: Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод бүрэн байршуулахаас 141 мэдээллийг байршуулж, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулах 1, сар бүрийн оруулах 3, улирал бүр оруулах 1, бүтэн жилээр оруулах 2 төрлийн мэдээлэл, нийт 8 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн системд байршуулвал зохих мэдээллийг тухай бүр үнэн зөв байршуулж байх..

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийл

5.Аудитын алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайланд хангамж бараа материалын зардлыг 4.595.7 мянган төгрөгийг илүү, эд хогшил урсгал засварын зардлыг 374.9 ,нормативт зардлыг 468.0, бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг 1.343.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан байна.	2	6,781.6	2	6,781.6						
2	2. Нэр бүхий албан тушаалтанд эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр орон тооноос илүү ажиллууж, 1.680.0 мянган төгрөгийн цалин олгосон	1	1,680.0							1	1,680.0
3	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардлаас НД-ийн тайлангийн цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд илүү тайлагнасан 1байна.	1	170.8							1	170.8
4	Тайлант хугацаанд нийт 23.432.1 мянган төгрөгийн худалдан авалт хийснээс худалдан авалтыг 13.648.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэгдсэн байна.	1	13,648.0					1	13,648.0		
5	Шилэн дансанд 148 мэдээлэл оруулахаас 141 мэдээллийг хугацаанд нь оруулж 7 мэдээллийг хугацаанаас хоцроосон байна.	1	-							1	
	НИЙТ ДҮН	5	22,280.4	1	6,781.6			1	13,648.0	3	1,850.8